



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/624

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4 дүгээр хуралдааны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Нийгмийн Ардчилал Монголын залуучуудын холбоо, Стратеги академитай хамтран зохион байгуулсан Баруун бүсийн “Манлайлал” сургалтыг манай аймагт зохион байгуулах зардлын дэмжлэгт 2 990 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 2 990 000 төгрөг /Хоёр сая есөн зуун ерэн мянган/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 4.8-д заасан Залуучуудын хөгжил дэд хөтөлбөр, арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02.3193
D/Zah-A/624-Bo

Аймгийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 29-ний өдрийн
А/624 дүгээр захирамжийн хавсралт



АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн Үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1.	Бэлгийн багц	ш	65	46.000	2 990.0
Дүн					2 990.0

-оОо-